

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ АРВАН ГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2018 оны тавдугаар сарын 24-ний 14 цаг 00 минутад эхэлж, 16 цаг 15 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 2 цаг 15 минут үргэлжлэв.

	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын танилцуулга	
2	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/09 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас: Идэшийн Батхүүг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/10 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн

		<p>албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Төмөр-Очирын Ням-Очирыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Л.Цэдэвсүрэн/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг нэр дэвшүүлэх тухай	<p>Нэр дэвшүүлэх тухай Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/11 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Төмөр-Уяагийн Жамбалцэрэнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Энхбат/-д санал болгосугай. болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн

	<p>даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг нэр дэвшүүлэх тухай</p>	<p>жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/12 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Ядамсүрэнгийн Эрдэнэсайханыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Энхбат/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
6	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14 дүгээр зүйлийн "а", Сонгон шалгаруулах комиссын Д/13 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Батжаргалын Дэлгэржаргалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Нандинжаргал/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
7	<p>Баян-Өлгий аймгийн Засаг даргаар 2007-2012 онд ажиллаж байсан</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73</p>

	<p>С.Хавалыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>дугаар тогтоол, иргэн С.Хавалын хүсэлтийг тус тус үндэслэн, Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>Баян-Өлгий аймгийн Засаг даргаар даргаар 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд томилогдон ажиллаж байсан Сакейн Хавалыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
8	<p>Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь салбар зөвлөлөөс 2018 оны 5 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын Төв комиссын саналыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэгдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 29 иргэнийг “Дэс түшмэл”-ийн, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 6 иргэнийг “Туслах түшмэл”-ийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн</p>

	<p>иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 6 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 5 иргэнийг тус тусын албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Нэр дэвшсэн 11 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах, нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн хүрээнд нөхөх арга хэмжээ авах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээллэх, иргэдэд сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дорнод аймаг дахь Салбар зөвлөл /П.Бат-Өлзий/-д үүрэг болгох.</p> <p>4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн /С.Цэдэндамба/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын</p>
--	---

		<p>8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлөөс 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын Төв комиссын саналыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас:</p> <ol style="list-style-type: none">1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэгдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг “Дэс түшмэл”-ийн, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 2 иргэнийг “Туслах түшмэл”-ийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд тус тус бүртгэх.2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад нэр дурдсан Алтбазарын Азаяа, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад нэр дурдсан Бат-Очирын Эрдэнэбилэг нарыг тус тусын албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх3. Нэр дэвшсэн 2 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд
--	--	---

		<p>томилуулж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Дархан-Уул аймаг дахь Салбар зөвлөл /Ч.Энхбат/-д үүрэг болгох</p> <p>4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн /С.Цэдэндамба/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлөөс 2018 оны 5 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын Төв комиссын саналыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаас</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэгдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 15 иргэнийг “Дэс түшмэл”-ийн, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 21 иргэнийг “Туслах түшмэл”-ийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан гуравдугаар хавсралтад дурдсан нэр бүхий 9 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх</p>
--	--	--

		<p>орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авсан дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 11 иргэнийг тус тусын албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Нэр дэвшсэн 20 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах, нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөгдөөгүй ажлын байруудыг хуулийн хүрээнд нөхөх арга хэмжээ авах, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй мэдээллэх, иргэдэд сургалт, зөвлөгөө өгч ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл /Ө.Сувдаа/-д үүрэг болгох.</p> <p>4.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн /С.Цэдэндамба/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
9	Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.3, “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2 дахь заалт, 2013 оны 105 дугаар

	<p>тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг тус тус үндэслэн Булган аймаг дахь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь Салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн батлах. Үүнд:</p> <p>Салбар зөвлөлийн дарга</p> <ul style="list-style-type: none"> - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга <p>Гишүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга - Аймгийн тэргүүлэх аудитор - Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга - Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга - Мэргэжлийн хяналтын газрын дарга - Шүүхийн Тамгын газрын дарга - Булган сумын Засаг даргын Тамгын газрын дарга <p>Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга</p> <ul style="list-style-type: none"> - Хүний нөөцийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн <p>2. Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь Салбар зөвлөлийг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж,</p>
--	--

		<p>дүгнэлт гаргаж нэр дэвшүүлэх, албан тушаалын зэрэг дэв олгох, албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлага, ёс зүй, төрийн албатай холбогдон гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Баатарзоригт, Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг зохион байгуулж, нэр дэвшүүлэх, төрийн албанд анх орох иргэний болон төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлэх, албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг гишүүн С.Цэдэндамбад тус тус үүрэг болгох</p> <p>3. Төрийн албаны тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Булган аймаг дахь салбар зөвлөлийн дарга Б.Ууганбаярт үүрэг болгох</p> <p>4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, дарга, нарийн бичгийн дарга нарыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Нэг”-ийн 4 дэх хэсэг, 2 дугаар хавсралтын “Хоёр”-ын 4 дэх хэсийг тус тус хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
10	Гаалийн ерөнхий газарт хийсэн	Төрийн албаны тухай хуулийн

	шалгалтын дүн танилцуулах	<p>4 дүгээр зүйлийн 4.1,4.2, 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйлийн 39.5, 39.6, Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “хоёр”-ын 2.2.1 дэх хэсгийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Гаалийн байгууллагад хяналт, шалгалт хийсэн дүнг хэлэлцээд:</p> <p>Нэг. Гаалийн байгууллага нь 2017 онд улсын төсөвт 1897.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 1950.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 2.8 хувиар буюу 53.4 тэрбум төгрөгөөр давуулан биелүүлж, хуулиар хүлээсэн зарим чиг үүргээ хэрэгжүүлсэн байна гэж үзсүгэй.</p> <p>Хоёр.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүднээс Гаалийн ерөнхий газрын дарга /Б.Асралт/-д дараах үйл ажиллагааг зохион байгуулах талаар ажлын нарийвчилсэн төлөвлөгөө гарган ажиллахыг даалгах. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу шалгалт өгөөгүй энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан 6 иргэнийг томилсон шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх, 2. Гаалийн байгууллагад анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан 24 иргэнийг томилсон шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэх,
--	---------------------------	---

		<p>3. Засгийн газрын болон Сангийн сайдын баталсан гаалийн байгууллагын бүтэц, орон тоонд байхгүй “мэргэжилтэн”-ий орон тоонд төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлээр томилон ажиллуулж байгаа энэхүү тогтоолын 3 дугаар хавсралтад дурдсан 18 иргэнийг томилсон шийдвэрийг тус тус хууль тогтоомжид нийцүүлж, зөрчлийг арилгах,</p> <p>4. Энэхүү тогтоолын 4 дүгээр хавсралтад дурдсан 56 албан тушаалын томилгоог Монгол Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, “б”-д нийцүүлж, Салбар зөвлөлийн дүгнэлт гаргуулах,</p> <p>5. Гаалийн байгууллагын өөрчлөлт, хөгжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, хөдөлгөөн байршуулалтыг хууль тогтоомжийн дагуу хийхдээ төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа /гэр бүл, орон сууц гэх мэт/-г Төрийн албаны тухай хууль болон, Гаалийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулах.</p> <p>6. Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам", Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”-ыг баримталж ажиллах, Ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгах,</p>
--	--	---

		<p>7. Гаалийн ерөнхий газрын харьяа бусад байгууллагуудад төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт, шалгалтыг үргэлжлүүлэн хийж, илэрсэн зөрчлийг арилгах.</p> <p>Гурав. Энэхүү тогтоолоор 1,2,3 дахь хэсэгт заасан зөрчлийг яаралтай арилгаж, 2018 оны 07 дугаар сарын 01-ний дотор тайланг ирүүлэх, 4,5,6,7 дахь хэсэгт заасан ажлыг зохион байгуулж, тайланг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний дотор Төрийн албаны зөвлөд ирүүлэхийг үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	---

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**